

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +22
Шинэ +7

ДЭЛХИЙ

ОХУ АНУ-ЫГ УЛС ТӨРД НӨЛӨӨЛСНИЙГ
ФЭЙСБҮҮК “ТОГТООЛОО”

IV нүүрт

СПОРТ

ТӨРИЙН ДАЛБААГАА УНГАРТ
МАНДУУЛСАН ЖУДОЧИД ЭХ
ОРОНДОО ИРЛЭЭ

V нүүрт

Дугаарын 60 мөр

АЙЛЧЛАЛ


Миний
хүүхдэд идэх
хоол алга

Б.ЭРХЭС

Би Монголын нийгмийн дэлжилэнх хувийн бүрдүүлж буй дундаж амьдралтай иргэдийн нэг. Ажлын таван одор борви бодисийнгүй ажиллаж, амралтын хоёр одрийг гэр бүлдээ зарцуулдаг жирийн л олон минган гэр бүлийн нэг нь манайх. Мэдээж амралтын хоёр одроо гэр бүлдээ зарцуулахын тулд хааяа гадуур хооллоо, кино узвэр үзэх эзргээр аль болох цагийг зөв боловсон онгөрүүлэх хэрэг гарна. Тэр болгонд зорьж очдог газар маань ч гарын таван хуруунд багтхаар цөөхөн. Баячуудын зиндаанд хүрэхгүй хойно нийслэлийнхээ дундаж үнэтэй ресторан, хоолны газраар гэр бүлээрээ үйлчлүүлэхийг хүсдэг ч харамсалтай нь манай нийслэлд гэр бүлийн ресторан миний мэдэхээр маш цөөхөн байх юм. Солонгос, Япон, Энэтхэг зэрэг ресторонаар тухай ярих ч хэрэггүй. Тэнд хүүхэд идчихээр хоол бараг л байхгүй учраас монгол хоолтой ресторанаа сонгож хооллоог чухалчилдаг юм. Гээтэл тэнд хүүхэд зориулсан хоолны цэс бараг л алга. Хaa изгяхн сүлжээ ресторанд хүүхдийн хоолны цэс харагддаг ч тэр нь шаржигнуур тахиа, төфөт, бантан гэх мэт тун цөөхөн хоолны сонголттой. Мэдээж таваас дээш наасны хүүхэд бол энэ хоолыг идчихэж болно.

Үргэлжлэл нь III нүүрт

Х.БАТТУЛГА: МИНИЙ МӨРӨӨДӨЛ ДАЛАЙД ГАРЧ, ГАЗРЫН БАЯЛГАА ДЭЛХИЙН ҮНЭЭР ЗАРАХ БОЛОМЖИЙГ ОЛОХ



Н.ПУНЦАГБОЛД

ОХУ-ын Владивосток хотноо Дорнын эдийн засгийн чуулганд оролцож байгаа Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга очигдэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтэй уулзав. Уудалтад Монголын талаас Монгол Улсаас Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, ОХУ-д суугаа Онц богеөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Дэлгэрмаа, Ерөнхийлөгч Тамгын газрын дарга З.Энхболд, Гадаад хариццааны дэд сайд Б.Батцэцгэг нарын албаны хүмүүс оролцоо. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин уулзалтын эхэнд хоёр усны хариццаа сүүлийн жилийндэд хэрхэн амжилттай хөгжжих байгаа талаар тодорхой төсөл хөтөлбөрүүдийг дурдлаа. Тэрбэр Монгол Улстай хамтран ажиллах хариццаанд хөдөө аж ахуй, тэр дундаа монгол малыг эрүүлжүүлэх болон дэд бүтцийн салбарын хөгжилд ихээхэн анхааралт хандуулж, цаашид хамтын ажиллагааг оргөжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийллээ.

Үргэлжлэл нь II нүүрт

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Ж.ЭРДЭНЭБАТЫН ЗАСГИЙН ГАЗАР ОГЦОРЛОО

Б.ЗАЯА

УИХ дахь МАН-ын бүлгийн 31 гишүүн гарын үсэг зурсан Засгийн газрыг огцруулах шаардлагыг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, Ж.Эрдэнэбатын Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорлоо. Нэгдсэн чуулган хураадаын омни буюу очигдэр огلوюноос эхээн УИХ-ын Тусгай хяналтын дэд хороо хаялттай хуралдаж, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын дэлгавраар Шадар сайд У.Хүрэлсүхийг тагнах чагнаас гэх асуудлыг хэлэлцэв. Огцруулах асуудлыг лхагва гаригт нэгдсэн чуулганаар хэлэлцэж эхэлсэн ч Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын хүснэгтээр Тусгай хяналтын дэд хороог хуралдуулахаар болж, МАН-ын бүлэг чуулганаар хуралдаанаас завсарлалаа аваад байсан юм.

Үргэлжлэл нь III нүүрт

МОНГОЛЬН МЭДЭЭ

Манай сонины
IV улирлын
захиалга
үргэлжилж
байна

Улиралд 64 дугаар

ЗАХИАЛГЫН ҮНЭ
22400

Монгол шуудан: 70078977

УБ шуудан: 70127027

Скай post: 70121294

Түгээмэл шуудан: 70115025

АЖИЛД АВНА

Гэрэл зурагчин
/зургийн аппараттай бол давуу тал болно/

Эх бэлтгэгч
/Indesign, Photoshop/

Сэтгүүлч
/2017 онд их, дээд сургууль төгссөн байж болно/

Утас: 99189158



ХААН банк

	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2434.00	2446.00	ФУНТ	3140.00	3215.00	АМ.ДОЛЛАР	2432.00	2446.00
ЕВРО	2884.00	2942.00	РУБЛЬ	41.80	43.70	ЕВРО	2887.00	2947.00
ИЕН	22.18	22.65	ЮАНЬ	371.00	377.40	ИЕН	22.05	22.65

Худалдаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах		
ФУНТ	3142.00	3218.00	РУБЛЬ	41.91	44.23	ЮАНЬ	371.00	376.40
ИЕН	3142.00	3218.00	ЮАНЬ	371.00	376.40			

Өчигдрийн 19.00 цагийн байдаа

СПОРТ



ТӨРИЙН ДАЛБААГАА УНГАРТ МАНДУУЛСАН ЖУДОЧИЛ ЭХ ОРЛОУДОО ИРЛЭЭ

Б.ДАВААХҮҮ

Унгарын нийслэл Будапешт хотод зохион байгуулагдсан Жудо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монголын жудо бөхийн шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчид бахархам амжилт үзүүлж, оногодоо 10.00 цагт эх ороандоо газардлаа.

Тэднийг жудо бөхийн дэмжгүйчид, гэр бүлийн гишүүд, харьяа байгууллагын удирдлагууд алд цэнхэр хадаг, аяга дүүрэн сүүгээ барин угтсан

юм. Энэ жилийн Дэлхийн аваргад Монголын жудоочид эрэгтэй, эмэгтэй тус бүр есон тамирчны бүрэлдэхүүнтэй оролцож, нэг алт, нэг мөнгө, дөрвөн хүрэл медаль хүртэж, шагналт тав, долдугаар байр тус тус нэгийг эзэлснээр багийн амжилтаар дэлхийн 126 орноос гуравдугаар байрт шалгарсан нь манай улсын спортын түүхэнд байгаагүй амжилттай байсан билээ. Жудоочид “Чингис хаан” нисэх онгоцны буудалд газарданыхаа дараа Орон нутгийн хурлын танхимд хэвлэлийн бага хурал зарлаж,

Монголынкоо ард түмэнд талархаж буйгаа илэрхийлсэн юм. Хурлын эхнд жудо бөхийн шигшээ багийн дасгалжуулагч, Монгол Улсын гавыят тамирчин О.Балжинийн “Манай жудо бөхийн шигшээ багийн дэлхийн хос медальтан боллоо. Г.Одбаяр Б. Монгончимэг нар маань анх удаа ДАШТ-ээс хүрэл медаль хүртлээ. Хамгийнхүнджинд Н.Түвшинбаяр аварга маань анх удаа +100 кг жинд барилдаж хүрэл медаль хүртэж олимпийн алт, монгөн медалии дэлхийн аваргын хүрэл медаль болгож олимп дэлхийн

байрт орж багийн дунгээр гуравдугаар байрт орсон түүхэн амжилт гаргалаа. 57 кг жинд Д.Сумьяа маань Олимпийн мөнгө, Дэлхийн аваргын хүрэл медаль болгож олимпийн алттан медаль зургаан медаль хүртсэн. Энэ нь Монголын түүхэнд байгаагүй түүхэн амжилт үзүүллээ. Медаль авахад багш дасгалжуулагч болон тамирчдын гэр бүлийнхэн болон Монголын ард түмэн энэ долоо хоног баярлалаа. Чин сэтгэлээсээ дэмжик байсан Монголын ард түмэндээ баярлалаа” гэв.

Үргэлжлэл нь VI нүүрт

FOOTBALL NEWS



Роналдо 430 мянган еврогоор
Ferrari F12 худалдах авчээ

Испанийн алдарт “Реал Мадрид” клубын довтлогч шинэ машинаахаа зурсуудыг өөрийн цахим хуудсандaa байршуулжээ.

Португалын ахлагч Ferrari F12 tdf машин авсан бөгөөд хамгийн багадаа 430 мянган еврогийн үнэтэй аж. Тэрхүү машин нь

хамгийн дээд тал нь 340 км/ц хурдлах чадалтай аж. Харин 2.9 секундын дотор 100 км/ц-ын хурд авдаг юм байна.

“Ливерпуул” залуу довтлогч
Вудбернтэй гэрээгээ
сунгана

АМЖИЛТЫН ЭЗЭН

Х.РАВДАНДОРЖ: Дэлхийн хэмжээний тэмцээнд оролцох зорилго өвөртөлж явна

Н.ЛУНЦАГБОЛД

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд өнгөрсөн наимдугаар сарын 19, 20-нд болсон “Өврийгээ ялах” 12 болон 24 цагийн гүйлтийн тэмцээнд оролцож, түрүүлсэн Х.Равдандоржийн ярилцаа. Тэрбээр 24 цагийн гүйлтийн төрөлд оролцож, түрүүлснээр спортын мастер цолны болзол хангасан юм.

-Юуны өмнө 24 цагийн турш гүйж, гайхалтай амжилт үзүүлсэнд чинь баяр хүргээ. Өмнө нь хонгөн атлетикийн спортоор хичээллэж байсан уу?

-Баярлалаа. Өмнө нь хонгөн атлетикийн спортоор хичээллэж байсангүй. Харин сонирхлоороо гүйж эхлэнээс хойш хоёр жил болж байна. Эхлээд алхадг байж байгаад гүйдэг болсон. Тэгээд гүйлтийн спортод бараг л донтолж, автаж эхэлсэн. Гүйх маш гоё санагддаг болсон л доо. Ингэж явсаар сая өөрийгөө сорьж үзэхээр шийдэж тэмцээнд орсон нь энэ. Урьд нь 42 км-ын марафонд гүйж байлаа. Нью-Йоркийн марафонд оролцохороо бэлтгэл хийж байсан. Еронхийдөө 42 км-ын зайд 3, 4 удаа гүйж үзсэн. Тэгээд энэ жилээс 12 болон 24 цагийн марафонд орж, өөрийгөө сорихыг хүссэн. Тэгээд л 24 цагийн гүйлтийн тэмцээнд оролцоод, Монгол Улсын спортын мастерын болзлыг хангасан. Мөн 24 цагийн гүйлтийн төрөлдөө түрүүлсэн.

-24 цаг тасралтгүй гүйсэн гэсэн үг үү?

-24 цагийн туршилт болох тасралтгүй гүйж, олон км зам туулах л ёстой юм. Удаан хугацаанд тасралтгүй гүйнэ гэдэг үнэхээр хэдийн юм билээ. Гэхдээ би гүйлтийн спортоор багино хугацаанд хичээллээд нийм том амжилт гаргаж чадсандаа баяртай байгаа.

-24 цаг гүйхэд ямар хүндэрэл гарч байв. Цаг

агаарын байдал тийм ч таатай байгаагүй гэсэн байх аа?

-Цаг агаарын байдал тун хүнд байсан. Би уг нь тэд орчим км гүйх байх гэж бодож байсан юм. Цаг агаар муу байсан болохор бодож байсан хэмжээндээ хүрч чадаагүй. Яг гүйх үед байгаа бороо орж байсан. Шивээрч байсангаа гэнэт ширүүсээд. Хувцас нойтон болчихood хүндэрлэгтэй байсан шүү. Уг нь бороо хэсэг ороод намджихвал гүйж байхад хувцас хатаад, гёй болчиход байхгүй. Гээтэл хувцас хатах ч боломжгүйгээр бороо орж байсан. Хувцас чадаар, хамаг биений бүлчин шөрмөс татах тохиолдол гарсан. Яахав, гүйж байхад шөрмөс татах үе бишгүй л гардаг. Гэхдээ бороогүй үед болохор гайгүй. Харин бороотойд, тэгээд олон цаг гүйхээр бүх тамирчдын шөрмөс татах, гар хуруу чангарах зүйл их тохиолдож байсан. Хэдийгээр бороо орж байгаа гээд олон янзын хувцас авчирсан ч гэсэн хатаах завдал өгөөгүй.

Үргэлжлэл нь VII нүүрт

Английн алдарт “Ливерпуул” клуб
багийнхаа залуу довтлогч Бен Вудбернтэй
гэрээгээ сунгахаар төлөвлөж байгаа ажээ.
Шинэ гэрээ урт хугацааныхаа байх юм
байна. Шинээр гэрээ байгуулах асуудлыг
удаагүй шийдвэрлэх аж. Вудберн саяхан
Уэльсийн шигшээ багийн төлөө гоолдож,
яялт авахад нь тус хүргэсэн билээ.
Магадгүй энэ нь түүний багтайгаа
гэрээгээ сунгахад нөлөөлсөн бололтой.

Жиовани Дос Сантос
Мексикийн шигшээн
төлөө 100 дахь тоглолтдоо
оролцлоо

2018 оны хөлбөмбөгийн дэлхийн аваргын Хойд Америкийн бүсийн урьдчилсан шатны хүрээнд Мексикийн шигшээ баг Коста Рикатай 1:1-ээр тэнцсэн билээ. Энэ тоглолтод “Лос Анжелес Галакси” клубын довтлогч Жиовани Дос Сантос оролцсон юм. Ингэснээр өдгөө 28 настай довтлогч шигшээ багийнхаа төлөө 100 дахь тоглолтдоо оролцлоо. Мексикийн хувьд 2018 оны дэлхийн аваргад оролцох эрхээ аваад байгаа билээ.

СПОРТ

АМЖИЛТЫН ЭЭЗН



Үргэлжлэл.
Түрүүч нь V нүүрт

Бүх хувцас норчихсон. Гурван цагийн давтамжтайгаар хувцасаа солих хэрэг гарна. Нэг пүзүүтэй гүйж байгаад л гурван цаг болоод шал нийтн болчихно. Тэгэхээр солиод, өөр пүзүүтэй өмсөх болно. Дахиад л солино. Энэ мэтээр цагаа хувцас солиход зарцуулахаар гүйж цагаас хасагдах байжшиштэй.

-24 цагийн турш гүйхдээ хэдэн км зам туулсан ба. Хэрвээ цаг агаар сайхан байсан бол илүү амжилт ч узүүлэх боломж байсан байх?

-181 км зам туулсан. Гэхдээ цаг агаар сайхан байсан бол үүнээс олон км зам гүйж байсан гэж хэлж чадахгүй л дээ. Ер нь бол өөртөө тавысан шаардлага, зорилбайсан. Гэвчийн майхтар бороотой уед зорилгодоо хүрнэ гэдэг хэдүү юм билээ. 24 цагийн хугацаанд 165 км зам туулбал спортын дэд мастерын болзол хангана. 180 км гүйвэл спортын мастерын болзол хангадаг юм. 195 км зам гүйвэл ОУХМ-ын болзол хангах ёстой. Би уг нь ОУХМ цол авахыг мөрөөдөж л байсан. Гэхдээ тэр мөрөөдөю хэнд ч хэлээгүй, зөвхөн өөртөө хадгалад л гүйжин. Яагаад гэвэл, хүнд ам гарчихад, дараа нь чадахгүй бол хэцүү шүү дээ. Тийм учраас өөртөө л зорилго тавиж, зүтгэсэн. Харамсалтай нь цаг агаарын хүнд нөхцлиөс болоод чадсангүй. Гэхдээ би спортын мастер цолыг авлаа. Сэтгэл хангалуун байгаа. Энэ тэмцээн “Өөрийгөө ялах” гэдэг нэрэндээ таарсан үнэхээр хүнд тэмцээн юм билээ. Тамирчны ялалт хямдхан олдогтгүй гээд дуу байдаг биз дээ. Түүнийг чинь их махаараа мэдрэсэн.

-24 цагийн турш гүйхдээ дунд нь хэдэн удаа хоол идэх ўу. Тогтсон дүрэм гэж бий ю?

-Байгүй яхав. Хэт холын марафоны холбоо, БТСХ, Шри Чинмойн марафоны баг гээд байгууллагууд хамтран зохион байгуулсан, энэ тэмцэнийг. Зохион байгууллагид маань дөрвөн цагийн зайдгаар халуун хоол, цайгаар үйлчилж байсан. Гүйжэд тохирохор, бие шингэцтэй, энерги нөхөх хоол өгнө. Мөн ямар нэг зүйл боломж бичигтэй хянагаар. Гүйж байх явцдаа өөрийнхөө цаг, минутыг тооцоод, хоолоо хэр халуун идэх вэ гэдгээ шийдээд л явчихнаа. Зарим нь зогсоод хоолоо иднэ. Би болохоор цаг алдахгүй тулд хөрөж байгаад л явдал дундаа хоол ундаа узж, идээд л явчихсан. Тэнд бол хувцасаа солих, бие засах, хоол

идэх минут бүр миний эсрэг ажиллаж байгаа юм. Болдог бол ямар ч зүйлд сатаарагчтай 24 цаг гүйвэл илүү сайн. Би энэ удаад бие засах цагаа хүртэл хэмнэж, ердөө л гурван удаа л 00 орсон. Өөртөө зорилго тавысан байсан учраас илүү зүтгэл гаргаж, тэмцсэн.

-24 цагийн турш гүйхдээ, спортын мастер цол хүртгүүлэх. Ямар ч байсан эхийн зорилгодоо хүрлээ. Гүйлтийн спортоор хичээллэж, амжилт гаргаж болох юм байна гэдгийг мэдэрчихлээ. Тийм болохор дараа дараачийн шинэ зорилтууд ундарч байгаа байх?

-Би эхндээ 12 цагийн гүйлтийд ороод узвэл яах бол гэсэн бодолтой байсан. Улмаар 24 цагийн гүйлтийд нь зорилж орсон. Анх удаа орж үзлээ. Үнэхээр хүнд гэдгийг нь мэдэрлээ. Гэхдээ би амжилттай оролцод, аврагаа нь болчихлоо. Үүний дараа шинэ зорилго гарч ирдэг юм байна. Болж өгвөл дэлхийн хэмжээний тэмцээнд оролцохыг бодож байгаа.

-Олимпийн төрлийн спорт өнөө үед илүү ач холбогдолтой болсон. 24 цагийн турш гүйхдээ, 181 км зам туулж болж байгаа юм чинь 42 км-ын марафонд оролцоод, Олимпийн наадамд өрсөлдөх боломж байхгүй юу?

-24 цагийн гүйлт гэдэг бол цэвэр тэсвэр тэвчээрийг шалгадаг спортын байна. Ямайкууд яагаад ойрын зайд ноёлдог билээ. Маш хурдан гүйдэг. Түүнтэй адил манай тамирчид хэт холын, хэний ч санаанд багтахаргуйтуулдаанд л ноёлдог байхыг хүсээд байгаа юм. Монголчууд л үүнийг чадлагад гэдгийг харуулмаар байна. Хэт холын марафон бол дэлхийд нэр хүндтэй байдал. Хүн бүр бишрэгээ, гайхдаг. Харин манайд хүмүүст сайн танигдаагүй байна. Тэмцээн болж байхад тэнд оролцож байгаа хэдэн хүн нь л байж байдаг. Сайндаа л 100 хүн л тэр тэмцээнийг мэдэж, мэдэрч,



ХРАВДАНДОРЖ: ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ТЭМЦЭНД ОРОЛЦОХ ЗОРИЛГО ӨВӨРТӨЛЖ ЯВНА


Тийм үедээ би “хамтдаа алхацаа” группийн ах, эгч нартай нэгдэж, хайрцагнаасаа гарахын тулд алхаж эхэлсэн. Энэ явцдаа хүмүүстүүтэй уулзаад, нүүр хагараад, өөртөө итгэхэд алхаж байгаа. Улмаар гүйгээд ирэхээр гаргүй ч гэсэн спортоор хичээллэж болох юм байна гэсэн итгэл, үнэмшиг олж авсан. Улмаар гүйгээд ирэхээр хүрэх байх даа?

-Тэдээхийн хэмжээний тэмцээнд оролцох зорилго-тойгэжбайсан. Тэгэхинтууд нэг байгууллагад харьяалагдаад, энэ спортоороо хичээллэвлээ илүү үр дүнд хүрэх байх даа?

-Хонгон атлетикийн спортын ойлгогод, хэт холын марафон гүйлтийн тамирчийн дэмжих сонирхолтой байгууллага байвал ивээн тэтгэж ажиллавал сайхан л байна. Хэрвээ тусалж дэмжээд, ивээн тэтгээд явахаа байгууллага олддог бол илүү их амжилт гаргах боломж нээлтэй л гэж хардаг. Би одоогоор Улаанбаатар шууданд ажилладаг л даа. Одоохондоо би энд тэнд байгууллагад хандаж байгаагүй. Өмнө нь амжилт гаргагүй байсан болохор юу ярьж очих билээ. Одоо амжилтаа гаргачихлаа, спортын мастер цолтой боллоо. Тийм болохор зорилгоо яриад очвол дэмжих байх гэж бодож байна. Цаашдын зорилго маань ч өөрчлөгдж, том болсон. Би анх 2013 онд осолд ороод, баруун гарсаа алдаж байсан юм. Тухайн үедээ өөрийгөө хайрцагт хийгээд, “миний амьдралдуусаа, онгөрсөн” гэсэн бодолтой болоод, нийгмээс өөрийгөө туслахад дамжуулж хэль.

-Сүүлийн асуултыг танд үзлээ?

-Хэт холын болон марафон тэмцээнд дэмжигчид маш их чухал байдаг. Гаргасан амжилтын мийн 50 хувь нь тэднийх. Миний гэрийн “Хамтдаа алхацаа” группийн ах, эгч нар маш их туслах дэмжицгээж, энэ их амжилтыг анх удаа гаргалаа. Тэр их бороотойд энд нар маань хөлөнд массаж хийхээс эхлээд л халуун хоол үнд зөөж өөрсдөө гүйж байгаа мэт цут л байсан. Тэдэндээ маш их баярлаж байгаагаа танай сониноор дамжуулж хэль.



ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

- [Сүхбаатар аймагийн Түвшинширээ сумын засаг даргын тамгын газар] нь [Түвшинширээ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах]-ыг хэрэгжүүлэх зорилгоо зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүснэгтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
 - Энэхүү зөвлөх үйлчилгээ нь [Түвшинширээ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах] болно.
 - Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Тийм
 - Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх
 - Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх
 - Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх
 - Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (ГБОНХОХБАУХАУУЛЫН 14-16 дугаар зүйлд заасан шалгууруудыг хангаж буйг нотлох баримт бичигийг) ирүүлэн. Үндээс
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Байгууллагын гэрчилгээний хуулбар
 - Тусгай зөвшөөрлийн хуулбар байна
 - Сүүлийн 2 жилийн /, 2015, 2016/ гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлага
 - Сүүлийн 2 жилийн /, 2015, 2016/ санхүүгийн тайлан
 - Зөвлөх хуудасын этгээдийн ажиллах боловсон хүчиний чадважийн талаарх мэдээлэл /Голлох инженер, техникийн ажилчдадын ур чадварын мэдээлэл, туршилага, зэргийн үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, гэрээт ажилтан бол ажлын гэрээг хавсаргах/ ирүүлэх
 - Чадважийн нэмэгдүүлж сайжруулах зорилгоо зөвлөхийд туншилзлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сонирхсон этгээдийн нэмээгээний мэдээллийг [2017.09.08-өөс 2017.09.19]-ийн [08:00-17:00] хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар [2017 оны 09 сарын 19-ны өдрийн 17:00-минут]-ийн дотор ирүүлнэ үү.
- /Сүхбаатар аймаг Түвшинширээ сумын ЗДТГазрын байранд
Засаг даргын орлогч Э.Эрдэнэбат утас 80594919

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

Төмөр овогтой Буяントогтохын 0055164 дугаартай газар өмчлөх шийдвэрийн
өрчилгээг хүчингүй тооцов.

